



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
2019 ОНЫ СТАТИСТИКИЙН
МЭДЭЭЛЭЛ**

УЛААНБААТАР

2020 ОН

Агуулга

1.Үндсэн үзүүлэлт	3
1.1 Зорчигч тээвэрлэлт	4
1.2 Зорчигч болон ачаа тээвэрлэлт.....	5
1.3 Ачаа тээвэрлэлт.....	6
2.Авто замын салбарын үндсэн үзүүлэлт.....	7
3.Автотээврийн салбарын үндсэн үзүүлэлт.....	10
3.1Тээврийн хэрэгсэл.....	11
3.2Импортын тээврийн хэрэгсэл	14
4.Төмөр замын тээврийн салбарын үндсэн үзүүлэлт.....	18
5.Агаарын тээврийн салбарын үндсэн үзүүлэлт	20
6.Усан зам, далайн тээврийн салбарын үндсэн үзүүлэлт	23
7.Зам, тээврийн ослын талаарх мэдээлэл.....	25
8. Дүгнэлт.....	29
Хавсралт.....	31

1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ *

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он
Сайжруулсан авто замын нийт урт, км **	10 126,0	10 355,2	10 835,8	11 593,4
Үүнээс: Хатуу хучилттай, км	7 456,6	8 431,4	9 022,7	9 781
Хайрган хучилттай, км	1 696,8	1 308,9	1 207,9	1 207,9
Сайжруулсан хөрсөн зам, км	972,6	614,9	604,9	604,9
Гүүрийн урт, у/м**	34 410,2	35 251,0	35 318,4	36 214,7
Төмөр замын нийт урт, км***	1 815,0	1 815,0	1 920,0	1 943,1
Агаарын тээврийн замын тоо ****	-	62	62	62
Автотээвэр				
Зорчигчдын тоо, сая хүн	260,7	212,2	193	168,44
Зорчигч эргэлт, сая хүн.км	1 959,9	2 040,9	2 919,9	2 925,09
Тээвэрлэсэн ачаа, мян.тн	20 406,2	31 212,9	42 033,8	40 848,8
Ачаа эргэлт, сая тн.км	4 236,2	5 661,3	6 640,61	6 203,78
Тээврийн орлого, тэрбум төгрөг	467,2	506,4	695,86	796,06
Тээврийн хэрэгслийн тоо, ш *****	841 552	900 145	970 846	1 049 485
Агаарын тээвэр				
Зорчигчдын тоо, сая хүн****	1,0	1,2	1,42	1,62
Зорчигч эргэлт, сая хүн.км	2 072,4	2 420,2	2 684,2	3 119,2
Тээвэрлэсэн ачаа, тн****	4 852	5 369	5 752	5 761
Ачаа эргэлт, сая тн.км	12,2	13,2	13,6	13,41
Тээврийн орлого, тэрбум төгрөг	287,3	385,5	442,2	498,2
Төмөр замын тээвэр				
Зорчигчдын тоо, сая хүн	2,64	2,63	2,57	2,95
Зорчигч эргэлт, сая хүн.км	955,5	973,2	993,7	1 113,38
Тээвэрлэсэн ачаа, мян.тн	19 989,1	22 765,0	25 763,3	28 121,2
Ачаа эргэлт, сая тн.км	12 371,0	13 493,3	15 315,3	17 346,8
Тээврийн орлого, тэрбум төгрөг	441,8	530,0	616,48	708,62
Усан замын тээвэр				
Зорчигчдын тоо, сая хүн	0,03	0,02	0,02	0,03
Зорчигч эргэлт, сая хүн.км	0,68	0,4	0,6	0,6
Тээвэрлэсэн ачаа, мян.тн	-	-	-	-
Тээврийн орлого, тэрбум төгрөг	0,23	0,30	0,5	0,4

*ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

**АЗБХЗГ-ын мэдээлэл


***ТЗДТБХЗГ-ын мэдээлэл

****ИНЕГ-ын мэдээлэл

*****“АТҮТ” ТӨҮГ-ын VRS автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн мэдээлэл

*****МУ-ын Далайн Захиргааны мэдээлэл

1.1. ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ



1.2. ЗОРЧИГЧ БОЛОН АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ

Зам, тээврийн салбар 2019 онд бүх төрлийн тээврээр тээвэрлэсэн нийт ачаа 68,9 сая тонн, зорчигчид давхардсан тоогоор 173 сая хүн болж, өмнөх оноос тээвэрлэсэн ачаа 1,17 сая тонн буюу 1,7%-иар өсөж, зорчигч 23,99 сая хүн буюу 12,2%-иар буурсан байна.


Зорчигч тээвэр: 2019 онд тээвэрлэсэн нийт зорчигчийн 97%-ийг автотээврээр тээвэрлэсэн байна. /График 1/

- Авто тээврээр 2019 онд давхардсан тоогоор 168,44 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос зорчигчид 24.56 сая хүн буюу 12.7%-иар буурсан байна.
- Төмөр замын тээврээр 2019 онд зорчигчид давхардсан тоогоор 2,95 сая хүн болж, өмнөх оноос зорчигчид 350 мянган хүн буюу 13,5%-иар өссөн байна.
- Агаарын тээврээр 2019 онд зорчигчид 1,62 сая хүн болж, өмнөх оноос зорчигчид 0,01 сая хүн буюу 15,7%-иар өсжээ.
- Усан замын тээврээр 2019 онд 30,9 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оныхоос зорчигчийн тоо 5316 хүн буюу 20,7%-иар өссөн байна.



Ачаа тээвэр: Нийт ачаа тээврийн 59,2%-ийг автотээврээр, 40,7%-ийг төмөр замын тээврээр, 0,001%-ийг агаарын тээврээр тээвэрлэсэн байна. /График 2/

- Автотээврээр 2019 онд 40,8 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос тээвэрлэсэн ачаа сая тонн буюу 2,8%-иар буурсан байна.
- Төмөр замаар 2019 онд 28,1 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 2 357,9 тонн буюу 9,2% өссөн байна. Нийт ачаанд дотоодын ачаа 11 сая тонн буюу 39,3%, экспортын ачаа 10 сая буюу 36,3%, импортын ачаа 2,9 сая тонн буюу 10,6%, дамжин өнгөрсөн ачаа 3,9 сая тонн буюу 13,8%-ийг тус тус эзэлж байна.
- Агаарын тээврээр тээвэрлэсэн ачаа 2019 онд 5761 мянган тонн болж, өмнөх оноос тээвэрлэсэн ачаа 9 тонн буюу 0,16%-иар өссөн байна.



1.3. АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ

5,76
мянган тонн

Өмнөх оноос
0,16% ↑

- Олон улс- 5407 тн; ↓
- Орон нутаг- 354 тн; ↑



40,8
сая тонн

Өмнөх оноос
2,8% ↓



28,1
сая тонн

Өмнөх оноос
9,2% ↑

- Орон нутгийн- 11.05 сая.тн; ↑
- Экспорт- 10,2 сая.тн; ↑
- Дамжин өнгөрөлт- 3,89 сая.тн; ↑
- Импорт- 2,98 сая.тн; ↑



Нийт **69** САЯ ТОНН
ачаа тээвэрлэсэн нь

өмнөх оноос 1,7% ↑

НИЙТ АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ:

- Автотээвэр- 59,2%
- Төмөр замын тээвэр- 40,7%
- Агаарын тээвэр- 0,001%

2.АВТО ЗАМЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ*

Монгол Улсын Авто замын тухай хуулийн 4.1.22, 14.1**–т заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ. Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2019 оны жилийн эцсээр 111916,7 км байгаагийн 100323,28 км нь буюу 89,6% нь ердийн хөрсөн, 11593,42 км буюу 10,4% нь сайжруулсан зам байна. /График 3/

Нийт сайжруулсан замын 9781 км буюу 84,4%-ийг хатуу хучилттай, 1207.9 км буюу 10,4%-ийг хайрган хучилттай, 604.9 км буюу 5,2%-ийг сайжруулсан хөрсөн зам эзэлж байна. /График 3/




График 3. Монгол Улсын үндэсний авто замын сүлжээ



Монгол Улсын авто замын нийт сүлжээнд олон улсын болон улсын чанартай зам 14 918,7 км буюу 13,3%, орон нутгийн чанартай зам 96125,3 км буюу 85,9%, уул уурхайн буюу тусгай зориулалттай зам 872,7 км буюу 0,8%-ийг эзэлж байна.

Хатуу хучилттай зам 2019 онд нийт 9781 км болж өмнөх оныхоос 758 км буюу 8,4%-иар өсч, харин хайрган хучилттай зам 1207.89 км, сайжруулсан хөрсөн зам 604.9 км хэвээр байна.

* АЗБХЗГ-ын мэдээлэл

** Авто замын тухай шинэчилэн батлагдсан хууль, 2017




График 4. Хатуу хучилттай авто замын бүтэц

Хатуу хучилттай замын 7469 км буюу 76,4% нь улсын, 1438,78 км буюу 14,7% нь орон нутгийн, 872,7 км буюу 8,9% нь уул уурхайн (тусгай) зориулалттай зам байна. /График 4/

Хатуу хучилттай авто замыг хучилтын төрлөөр авч үзвэл 9490 км буюу 97%-ийг асфальт бетон, 205,2 км буюу 2%-ийг хөнгөвчилсэн хучилттай, харин цемент бетон зам 116,16 км буюу 1%-ийг эзэлж байна. /График 5/




График 5. Хатуу хучилттай авто замын хучилтын төрөл

Асфальт бетон зам 2019 онд 9490 км болсон нь өмнөх оныхоос 783,6 км буюу 9%-иар нэмэгдсэн. Харин хөнгөвчилсэн хучилттай болон цемент бетон замын хэмжээ нь өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна.

Гүүр. Улсын хэмжээнд 2019 онд нийт 643,65 урт метр гүүр шинээр ашиглалтад оруулж жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 716 ширхэг 35962 метр урттай гүүр байна.


Хүснэгт 1.

Үндэсний авто замын сүлжээ

Авто замын төрөл	Хэмжих нэгж	Бүгд	Үүнээс		
			Улсын чанартай	Орон нутгийн чанартай	Уул уурхайн зориулалттай зам
Авто замын сүлжээний нийт урт	км	111916.7	14918.7	96125.3	872.7
Үүнээс:					
1. Хатуу хучилттай	км	9781	7469	1438.78	872.7
а. Цемент бетон	км	111.16	36.50	31.46	43.2
б. Асфальт бетон	км	9490.0	7227.5	1407.32	855.2
в. Хөнгөвчилсэн	км	205.2	205.2	-	-
2. Хайрган хучилттай	км	1207.89	923.56	284.33	-
3. Сайжруулсан хөрсөн	км	604.9	211.9	393	-
4. Ердийн хөрсөн зам	км	100323.28	6314.1	94009.19	-



Авто замын салбарт **2016-2019** онд нийт **1773.33** км хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулсан бөгөөд эдгээр төслүүд хэрэгжиж дууссанаар нийт **17** аймгийн төв, **95** сум, **5** хилийн боомт хатуу хучилттай авто замаар нийслэлтэй холбогдож Улсын чанартай авто замын сүлжээний нийт **7227.5** км буюу **48.4** хувь нь хатуу хучилттай авто замаар ашиглагдаж байна.

 Одоо ашиглагдаж байгаа улсын чанартай Хатуу хучилттай авто замын урт

7227.5 км

2016 онд ашиглалтад орсон авто зам, гүүр

199.52 км, 145.65 у/м

2017 онд ашиглалтад орсон авто зам, гүүр


441.59 км, 489.8 у/м

2018 онд ашиглалтад орсон авто зам, гүүр

383.72 км, 202.4 у/м


2019 онд ашиглалтад орсон авто зам, гүүр

748.5 км, 643.65 у/м


 Авто замын салбарт **2020 онд** баригдах томоохон авто замын төсөл, арга хэмжээнүүд

3.АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ*

Автотээврийн салбар 2019 онд давхардсан тоогоор 168,44 сая хүн зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 2925,9 сая хүн.км болж, өмнөх оныхоос зорчигчийн тоо 24.6 сая хүн буюу 12.7%-иар буурч, зорчигч эргэлт 5,2 сая хүн.км буюу 0,2%-иар өссөн байна. /График 6/



Автотээврээр 2019 онд 40848,75 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 185 мян.тн буюу 2,8%-иар бууржээ. /График 7/



Автотээврийн ачаа эргэлт 2019 онд 6203,78 сая тн.км болж, өмнөх оныхоос 436,8 сая тн.км буюу 6,6%-иар буурсан байна.

2019 онд автотээврийн салбарын нийт орлого 796,06 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 100,2 тэрбум төгрөг буюу 14,4%-иар өссөн байна. /График 8/



* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

** "АТҮТ" ТӨҮГ-ын VRS автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн мэдээлэл

Тээврийн хэрэгсэл, 2019 он.**





График 9. Тээврийн хэрэгслийн төрөл, хувиар

Монгол Улсын тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо 2019 онд нийт 1043028 болж өмнөх оныхоос 72210 тээврийн хэрэгсэл буюу 7,4%-иар өссөн байна. Үүнээс 934510 буюу 89,5%-ийг автомашин, 46951 буюу 4,5%-ийг мотоцикл, 47972 буюу 4,6%-ийг чиргүүл, 13595 буюу 1,3%-ийг механизм тус тус эзэлж байна. /График9/

Нийт тээврийн хэрэгслийн 568866 буюу 54,5% нь Улаанбаатар хотод бүртгэлтэй, 474162 буюу 45,5% нь орон нутагт бүртгэлтэй байна.

График 10. Автомашины төрөл




Нийт 934510 автомашин бүртгэлтэй байгаа ба зориулалтаар авч үзвэл, 667375 буюу 64% нь суудлын, 203675 буюу 19.5% нь ачааны, 19535 буюу 1.9% нь автобус, 13582 буюу 1,3% нь тусгай зориулалтын автомашин, 6493 буюу 0,6% нь цистерн, 23850 буюу 2,3% нь зүтгүүр байна. /График 10/


Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашины тоо 530058 буюу нийт автомашины 56,7%-ийг эзэлж байна. Орон нутагт 404452 буюу 43,3%-ийн автомашин байна. 2019 онд Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашины тоо өмнөх оныхоос 6,2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт тээврийн хэрэгслийн 801594 буюу 76,8% нь 10-аас дээш жил, 175722 буюу 16,8% нь 7-9 жил , 32424 буюу 3,1% 4-6 жил, 33300 буюу 3,2% нь 0-3 жилийн насжилттай байна. /График 12/

Тээврийн хэрэгслийн насжилт, 2019




Хүрдний байрлал



Баруун – 520452

Зүүн - 413690

2019 онд нийт бүртгэлтэй автомашины 413690 буюу 44,3% нь зүүн талдаа жолооны хүрдтэй, 520452 буюу 55,7% нь баруун талдаа жолооны хүрдтэй байна. Өмнөх оноос зүүн талдаа жолооны хүрдтэй автомашин 1,5%-иар, баруун талдаа жолооны хүрдтэй автомашин 12,2%-иар тус тус өссөн байна.




Хөдөлгүүрийн багтаамж	Тээврийн хэрэгсэл	Эзлэх хувь
1500 см³ хүртэл	380815	36,7%
1501-2500 см³	368266	35,5%
2501-3500 см³	120854	11,6%
3501-4500 см³	39605	3,8%
4501 см³ дээш	129116	12,4%

График 11. Хөдөлгүүрийн багтаамж

Нийт тээврийн хэрэгслийн 36,7% нь 1501 см³ хүртэл, 35,5% нь 1501-2500 см³, 11,6% нь 2501-3500 см³, 12,4% нь 4501 см³ дээш, 3,8% нь 3501-4500 см³ хөдөлгүүрийн багтаамжтай байна. /График 11/


Нийт автомашины 570286 буюу 70,1% нь бензин, 226855 буюу 27,9% нь дизель, 16601 буюу 2% нь газ, 276 буюу 0,03% нь цахилгаанаар ажилладаг хөдөлгүүр бүхий автомашин байна. /График 12/



Техникийн хяналтын үзлэгт 2019 оны байдлаар:

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар техникийн хяналтын үзлэгт 664537 тээврийн хэрэгсэл хамрагдсан нь өмнөх оноос 79174 буюу 13,5%-иар өссөн байна. Үүнээс суудлын автомашин 453927 хамрагдсан нь өмнөх оноос 27862 буюу 6,5%-иар өссөн, ачааны автомашин 124406, зүтгүүр 20323, автобус 10401, цистерн 2187, тусгай зориулалтын 7854, механизм 6534, чиргүүл 26339, мотоцикл 12552 хамрагдсан байна.

Монгол Улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслээс 664573 буюу 63,3% нь, нийт автомашины 619098 буюу 65,8%, нийт суудлын автомашины 453927 буюу 67,6% нь техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байна.



2019 онд улсын хэмжээнд нийт 158692 prius суудлын автомашин бүртгэгдсэн ба нийслэлд 120773, орон нутагт 37919 бүртгэгдсэн байна. Нийт суудлын автомашинд 23,6%-ийг prius эзэлж байна.

ИМПОРТООР ОРЖ ИРЖ БУЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

2019 оны жилийн эцсийн байдлаар импортоор нийт 158224 тээврийн хэрэгсэл орж ирснээс ангилалаар нь авч үзвэл суудлын автомашин 69472 буюу 43,9%, мотоцикл болон дугуйт тэрэг 39341 буюу 24,9%, ачааны автомашин 23050 буюу 14,6%, унадаг дугуй 12220 буюу 7,7%, хүнд машин механизм 11165 буюу 7,1%, тусгай зориулалтын, трактор болон нийтийн зориулалттай моторт тээврийн хэрэгсэл нь 2699 буюу 1,7%, бусад тээврийн хэрэгсэл нь 277 буюу 0,2%-ийг тус тус эзэлж байна. /График 13/

Импортоор орж ирсэн тээврийн хэрэгсэл:

- тээврийн хэрэгсэл - 158224
- суудлын автомашин - 69472 (43,9%)
- мотоцикл болон дугуйт тэрэг - 39341 (24,9%)
- ачааны автомашин - 23050 (14,6%)
- унадаг дугуй - 12220 (7,7%)
- хүнд машин механизм - 11165 (7,1%)
- тусгай зориулалтын, трактор болон нийтийн зориулалттай - 2699 (1,7%)
- бусад - 277 (0,2%)




График 13. Импортоор орж ирж буй тээврийн хэрэгслийн төрөл, 2019 он

Импортоор орж ирж буй тээврийн хэрэгсэл, төрлөөр, үнээр

Тээврийн хэрэгслийн ангилал	2015 он		2016 он		2017 он		2018 он		2019 он	
	тоо /шир/	үнийн дүн /мян.ам.дол/	тоо /шир/	үнийн дүн /мян.ам.дол/	тоо /шир/	үнийн дүн /мян.ам.дол/	тоо /шир/	үнийн дүн /мян.ам.дол/	тоо /шир/	үнийн дүн /мян.ам.дол/
Суудлын автомашин	37,086.0	209,967.6	37,735.0	219,679.2	48,870.0	260,382.7	64,039.0	407,847.0	69,472.0	418,739.5
Мотоцикл, дугуйт тэрэг	26,440.0	15,682.7	21,596.0	11,365.9	32,167.0	16,644.9	38,746.0	20,950.3	39,341.0	20,520.2
Ачааны автомашин	7,675.0	49,944.2	6,836.0	46,491.5	14,155.0	191,289.2	22,256.0	283,745.1	23,050.0	421,145.0
Унадаг дугуй.	13,237.0	511.7	14,735.0	800.2	15,300.0	868.0	15,886.0	940.5	12,220.0	642.0
Хүнд машин механизм	3,595.0	86,743.4	1,808.0	51,066.0	3,195.0	116,507.1	9,160.0	37,454.2	11,165.0	232,855.7
Тусгай/трактор, нийтийн/	1,646.0	38,747.7	2,055.0	49,623.0	1,700.0	33,062.1	1,990.0	36,992.8	2,699.0	56,642.8
Бусад	184.0	5,183.3	2,738.0	9,900.6	705.0	11,028.2	345.0	21,304.4	277.0	26,689.5
Нийт тээврийн хэрэгсэл	89,863.0	406,780.7	87,503.0	388,926.3	116,092.0	629,782.3	152,422.0	809,234.2	158,224.0	1,177,234.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортоор орж ирж буй үнэ:

- Тээврийн хэрэгсэл – 1177234,7 мян.ам.дол
- суудлын автомашин – 418739,5 мян.ам.дол
- ачааны автомашин – 421145 мян.ам.дол
- хүнд машин механизм – 232855,7 мян.ам.дол

2019 онд импортоор орж ирсэн нийт тээврийн хэрэгслээс 69472 буюу 43,9%-ийг суудлын автомашин эзлэж байна. Импортоор орж ирж буй суудлын автомашиныг 2018 онтой харьцуулахад 8,4%-иар, 2017 онтой харьцуулахад 42%-иар өссөн байна. 2018 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 152422 тээврийн хэрэгсэл орж ирснээс 64039 буюу 42%-ийг суудлын автомашин эзэлж байна. /График 14/



График 14. Импортоор орж ирж буй нийт тээврийн хэрэгсэлд эзлэх суудлын автомашин, (тоо хэмжээ, хувиар)

Нийт тээврийн хэрэгслийн үнийн дүн 1177234,7 мян.ам.дол байгаа бол суудлын автомашины үнийн дүн 418739,5 мян.ам.дол буюу нийт тээврийн хэрэгслийн 35.6%-ийг эзэлж байна. Гэвч суудлын автомашины тоо хэмжээ өссөн үзүүлэлттэй боловч үнийн дүн хангалттай өсөөгүй байгаа шалтгаан нь хямд үнийн дүнтэй автомашин ихээр оруулж ирж байгаа нь харагдаж байна. /График 15/



График 15. Импортоор орж ирж буй тээврийн хэрэгсэл болон суудлын автомашины нийт үнийн дүн (мян.ам.дол)


2018 оны жилийн эцэст импортоор орж ирж буй нийт суудлын автомашины 5,8% буюу 3688 эвдрэлтэй суудлын автомашин орж ирсэн бол 2019 оны 10 дугаар сарын байдлаар 4172 буюу 6,8%-ийн эвдрэлтэй суудлын автомашин орж ирсэн байна. Энэ үзүүлэлт цаашид өсөх хандлагатай байна. /График 16/



График 16. Импортоор ирж буй нийт суудлын автомашинд эзлэх эвдрэлтэй суудлын автомашины тоо

Тээврийн хэрэгслийн гол импортлогч орон нь Япон, Солонгос, Хятад, Герман, Америк, Орос, Канад, Швед, Их Британи, Австрали, Мексик, Австри зэрэг нийт 34 улс орон байна.

Импортоор суудлын автомашины 86.6% нь баруун талдаа жолооны хүрдтэй, 13.3% нь зүүн талдаа жолооны хүрдтэй бол ачааны автомашины 80% нь зүүн талдаа, 20% нь баруун талдаа жолооны хүрдтэй, автобусны 91.6% нь зүүн талдаа, 8.4% нь баруун талдаа жолооны хүрдтэй байна.



Импортоор орж ирж буй тээврийн хэрэгслийн 46% нь эрлийз хөдөлгүүртэй бол, 29% нь бензин хөдөлгүүртэй, 23% нь дизель хөдөлгүүртэй байна.

4.ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Улсын хэмжээнд 2019 оны байдлаар нийт 1943,1 км урт төмөр зам байгаа ба дэлгэмэл урт нь 2763,4 км байна. Монгол Улсад бүртгэлтэй 6572 ачааны вагон, 159 зүтгүүр, зорчигчийн 276 вагон төмөр замын хөдөлгөөнд оролцож байна. Гол зам дагуу өртөө зөрлөгийн тоо 71 байна.

2019 онд Төмөр замын тээврээр 2,9 сая хүн зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 379,8 мян.хүн буюу 13,5%-иар өсжээ. Нийт зорчигчдын 2,8 сая хүн буюу 96% нь орон нутагт, 79,7 мян.хүн буюу 2,7% нь гадаадруу, 30,72 мян.хүн буюу 10,4% нь гадаадаас, 6,12 мян.хүн буюу 0,2% нь дамжин өнгөрсөн байна. Олон улсын зорчигчийн тоо өмнөх оныхоос 1,4%-иар буурч, орон нутгийн зорчигчийн тоо 15,5%-иар өссөн байна. /График 19/

Төмөр замын зорчигч эргэлт 2019 онд 1113,38 сая хүн.км болж өмнөх оноос 119,7 сая хүн.км буюу 15%-иар өсжээ.



Төмөр замын тээврээр 2019 онд 28121,2 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 2357,9 мян.тн буюу 9,2%-иар өссөн байна. Төмөр замын тээврээр тээвэрлэсэн олон улсын ачаа 61%, орон нутгийн ачаа 39%-ийг тус тус эзэлж байна.

Төмөр замын тээврээр тээвэрлэсэн орон нутгийн ачаа тээвэрлэлт 11,05 сая тн буюу 39%, экспортоор нийт 10,2 сая тн буюу нийт ачааны 36%, импортоор нийт 2,98 сая тн буюу 11%, 3,89 сая тн буюу 14%-ийг дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлт эзэлж байна. /График 20/






График 22. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, ачааны нэр төрөл

Төмөр замын тээврээр тээвэрлэсэн ачааг нэр төрлөөр нь авч үзвэл 8642,66 мян.тн буюу 40.7% нь нүүрс, 8606.34 мян.тн буюу 40.6% нь уул уурхайн бүтээгдэхүүн, 2025.98 мян.тн буюу 9.6% барилгын материал, 557.29 мян.тн буюу 2.6% нь нефть, нефтийн бүтээгдэхүүн, 289.44 мян.тн буюу 1.4% ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, 201.94 мян.тн буюу 0.9% нь хүнсний бүтээгдэхүүн, 254.85 мян.тн буюу 1.2% нь хар төмөр, 117.213 мян.тн буюу 0,6% мод, модон материал, 10.6 мян.тн буюу 0,04% нь түргэн муудах бүтээгдэхүүн, 29.63 мян.тн буюу 0,1% нь үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, 517.07 мян.тн буюу 2,5% нь бусад ачаа тус тус эзэлж байна. /График 22/

Төмөр замын тээврийн ачаа эргэлт 17346,83 сая тн.км болж, өмнөх оныхоос 2031,5 сая тн.км буюу 13,3%-иар өссөн байна. Үүнээс 3141,91 сая тн.км буюу 18,1% нь орон нутаг, 8354,9 сая тн.км буюу 48,2% нь экспорт, 1528,69 сая тн.км буюу 8,8% нь импорт эзэлж байна.

Төмөр замын тээврийн орлого 2019 онд 708,62 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 92,6 тэрбум төгрөг буюу 15%-иар өссөн байна. /График 24/




5. АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Агаарын тээврийн салбар 2019 онд нийт 1,62 сая хүн зорчигч тээвэрлэж өмнөх оныхоос 0,2 сая хүн буюу 12,6%-иар өссөн байна.

Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо орон нутагт 433367 хүн болж өмнөх оныхоос 31760 хүн зорчигч буюу 8%, олон улсад 1188204 хүн болж өмнөх оныхоос 167313 хүн буюу 16%-иар тус тус өссөн байна. /График 25/



Агаарын тээврээр 2019 онд нийт ачаа 5761 тн тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 10 тн буюу 0,2%-иар өссөн байна. Нийт тээвэрлэсэн ачаанаас олон улсад 5678 тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 34 тн буюу 0,6%-иар өсч, орон нутагт 83 тн ачаа тээвэрлэсэн нь 25 тн буюу 23,1%-иар буурсан үзүүлэлттэй байна. /График 26/



2019 онд орон нутагт зорчигчдын тоо 433367 хүн болж, үүнээс зөвхөн уул уурхайн захиалгат нислэг Оюутолгой, Оюутолгой-Даланзадгад, Овоот чиглэлд зорчигчийн тоо 317392 хүн буюу 73%, орон нутгийн хуваарьт нислэгээр 115975 хүн буюу 27% тус тус эзэлж байна. /График 27/

Хүснэгт 3.

Олон улсын зорчигч тээвэрлэлт, чиглэл тус бүрээр


Чиглэл	2018 он	2019 он	2019/2018	
			Хувиар	Тоогоор
Бээжин	210,500	214,567	1.9%	4,067
Сөүл	361,339	387,740	7.3%	26,401
Хонг конг	69,937	88,846	27.0%	18,909
Токио	69,795	79,118	13.4%	9,323
Москва	74,216	94,890	27.9%	20,674
Берлин	14,910	17,072	14.5%	2,162
Москва-Берлин	8,367	11,820	41.3%	3,453
Бусан	54,960	64,498	17.4%	9,538
Бангкок	13,019	10,547	-19.0%	(2,472)
Франкфурт	9,929	10,604	6.8%	675
Осака	-	3,608		3,608
Гуанжоу	-	13,686		13,686
Манжуур	13,629	5,941	-56.4%	(7,688)
Улаан-Үүд	4,972	7,717	55.2%	2,745
Эрээн	18,938	50,608	167.2%	31,670
Бугат	3,848	-	-100.0%	(3,848)
Хайлаар	2,969	11,127	274.8%	8,158
Хөх хот	11,609	15,913	37.1%	4,304
Эрхүү	15,860	14,293	-9.9%	(1,567)
Бишкек- Стамбул	42,058	41,387	-1.6%	(671)
Нурсултан	-	10,491		10,491
Тяньжин		1,207		1,207
Захиалгат	20,036	32,524	62.3%	12,488
НИЙТ	1,020,891	1,188,204	16.4%	167,313

Агаарын тээврээр олон улсад 1188204 хүн зорчсон бөгөөд үүнээс дотоодын 3 агаарын тээвэрлэгч “МИАТ” ХК 589361 хүн, “Хүннү Эйр” ХХК 77681 хүн, “Аэромонголиа” ХХК 24696 хүн зорчигч тус тус тээвэрлэсэн. Гадаадын 8 агаарын тээвэрлэгч “Кореан Эйр” 167486 хүн, “Эйр Чайна” 101612 хүн, “Аэрофлот” 72506 хүн, “Туркиш Эйрлайнс” 41387хүн, “Эйр Бусан” 40894 хүн, “Ашиана Эйрлайнс” 35297 хүн, “Ангара Эйрлайнс” 3080 хүн, СКАТ 10491 хүн, захиалгат нислэгээр 8896 мян.хүн зорчигчийг нийт 22 чиглэлд тус тус тээвэрлэсэн байна /Хүснэгт 3/.

Монгол Улсын агаарын зайд 2019 онд нийт 151772 нислэг үйлдэгдсэн нь өмнөх оныхоос 13577 нислэг буюу 9.8%-иар өссөн байна. Үүнээс 133663 нислэг нь олон улсын өнгөрөлтийн нислэг бөгөөд өмнөх оныхоос 10367 буюу 8.4%-иар өссөн нь нийт нислэгийн 88%-ийг, харин хөөрөлт, буултын тоо 18109 байгаа нь нийт нислэгийн 12%-ийг эзэлж байна. 2018 онд олон улсын хөөрөлт, буултын тоо 10142 байсан нь өмнөх оныхоос 1637 буюу 19.2%, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 7967 байсан нь өмнөх оныхоос 1573 буюу 24.6%-иар тус тус өссөн байна. /График 28/.




Агаарын тээврийн салбарын орлого 2019 онд 498.2 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 55.9 тэрбум төгрөг буюу 12.6%-иар өссөн байна /График 29/.




6.УСАН ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ*

2019 онд усан замын тээврээр 30954 хүн зорчиж, зорчигч эргэлт 0.6 сая хүн км болж, өмнөх оныхоос зорчигчийн тоо 5271 хүн буюу 20.5%-иар өссөн байна. Нийт зорчигчдийн 27354 дотоодын иргэд бол 3 600 гадаадын иргэд байна. Зорчигч эргэлт 643168 хүн.км байна. /График 30/



Усан замын тээврээр 1990 онд 71,6 мян.тн ачаа тээвэрлэж байсан бол 2006-2019 онд ачаа тээвэрлээгүй байна.

Усан замын тээврийн орлого 2019 онд 377.5 сая төг болж, өмнөх оныхоос 33%-иар буурсан үзүүлэлттэй байна. /График 31/



2019 онд зохион байгуулсан техникийн хяналтын үзлэгт 124 тээврийн хэрэгсэл хамрагдаж, тэнцсэн-96, тэнцээгүй-11, засвартай-17, хамрагдаагүй-32 тээврийн хэрэгсэл байна.

Нийт усан замын тээврийн хэрэгслийн 71,03 хувь буюу 103 тээврийн хэрэгсэл нь Хөвсгөл аймагт, Архангай 17, Улаанбаатар 7, Дархан-Уул 1, Орхон 2, Баян-Өлгий 2, Булган 4, Сэлэнгэ 2, Дорнод 2, Увс 4, Хэнтий аймагт 1 усан замын тээврийн хэрэгсэл тус тус улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. /Хүснэгт 4/

* МУ-ын Далайн Захиргааны мэдээлэл

** 2018 оны техникийн хяналтын үзлэг, тооллогын тайлан

Аймаг, орон нутгийн нэр	Хөвсгөл	Архангай	Улаанбаатар	Дархан-Уул	Орхон	Баян-Өлгий	Булган	Сэлэнгэ	Дорнод	Увс	Хэнтий	Нийт
Усан замын тээврийн хэрэгслийн тоо	103	17	7	1	2	2	4	2	2	4	1	145

Усан замын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлд 2019 оны жилийн эцсийн байдлаар улсын дугаар, гэрчилгээтэй 145 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн дүнтэй байна. 2019 онд шинээр 26 усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэгдэж, гэрчилгээ, улсын дугаар олгосон. Бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийлгэхээр аж ахуй нэгж, иргэнээс ирүүлсэн 7 хүсэлт, өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Монголын хөлөг онгоцны бүртгэлийн мэдээлэл

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 31 улсын 374 хөлөг онгоц бүртгэлтэй их далайд үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын далбаатай хөлөг онгоцыг эзэмшигч улсын харьяаллыг хүснэгтээр үзүүлэв.

Монгол Улсын далбаатай хөлөг онгоцыг эзэмшигч улс

№	Улс	Хөлөг онгоцны тоо	Хувиар /%I
1	Singapore	96	25.67
2	Malaysia	61	16.31
3	Hong Kong	47	12.57
4	Indonesia	18	4.81
5	Panama	16	4.28
6	Marshal Islands	15	4.01
7	Taiwan	13	3.48
8	Japan	12	3.21
9	BVI	11	2.94
10	China	11	2.94
11	Seychelles	11	2.94
12	Vietnam	11	2.94
13	UAE	8	2.14
14	Belize	7	1.87
15	UK	7	1.87
16	Malta	5	1.34
17	Philippines	5	1.34
18	Anguilla	3	0.80
19	India	2	0.53
20	Korea	2	0.53
21	Samoa	2	0.53
22	Suriname	2	0.53
23	Bangladesh	1	0.27
24	Cambodia	1	0.27
25	Greece	1	0.27
26	Leberia	1	0.27
27	Qatar	1	0.27
28	Russia	1	0.27
29	Spain	1	0.27
30	Thailand	1	0.27
31	Turkey	1	0.27
Нийт		374	100

7. ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Улсын хэмжээнд 2019 онд зам, тээврийн ослын шинжтэй 77444 дуудлага хүлээн авч, 25302 зам, тээврийн осол бүртгэн шалгасан байна. Харин 2018 онд 81211 дуудлага хүлээн авч, 29474 осол бүртгэгдсэн байсан нь 2019 оныхоос дуудлага 3767 буюу 4,6%-иар, бүртгэгдсэн осол 4172 буюу 14,2%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд хүлээн авсан дуудлагын 96%, бүртгэгдсэн ослын 86,5%-ийг НИЙСЛЭЛ эзэлж байна. /Хүснэгт 6/

Хүснэгт 6.


Зам, тээврийн ослын шинжтэй дуудлага

Он	Улсын хэмжээнд		Нийслэл		Орон нутагт	
	Улсын хэмжээнд хүлээн авсан дуудлагын тоо	Улсын хэмжээнд бүртгэгдсэн осол	Нийслэлд хүлээн авсан дуудлагын тоо	Нийслэлд бүртгэгдсэн осол	Орон нутагт хүлээн авсан дуудлагын тоо	Орон нутагт бүртгэгдсэн осол
2018	81211	29474	77306	25666	3905	3808
2019	77444	25302	74082	21874	3362	3428

Нийслэлд бүртгэгдсэн зам, тээврийн осол:

- Баянзүрх дүүрэг 4508 өмнөх оноос 1355 буюу 23,1%-иар буурсан
- Баянгол 4823 өмнөх оноос 693 буюу 12,6%-иар буурсан
- Сонгинохайрхан 4269 өмнөх оноос 298 буюу 6,5%-иар буурсан
- Хан-Уул 3761 өмнөх оноос 81 буюу 2,2%-иар өссөн
- Сүхбаатар 2537 өмнөх оноос 802 буюу 24%-иар буурсан
- Чингэлтэй 1706 өмнөх оноос 783 буюу 31,5%-иар буурсан
- Багануур 36 өмнөх оноос 17 буюу 47,2%-иар буурсан
- Багахангай 13 буюу өмнөх оноос 4 буюу 44,4%-иар өссөн
- Налайх 221 буюу өмнөх оноос 89 буюу 67,4%-иар өссөн

Орон нутагт бүртгэгдсэн зам, тээврийн ослын үзүүлэлт



Улсын хэмжээнд 25302 зам, тээврийн осол бүртгэн шалгасны 22064 буюу 87,2% нь эд материалын хохиролтой осол, 3238 буюу 12,8% нь хүн гэмтсэн /хүний амь нас, эрүүл мэнд хохирсон/ зам тээврийн осол байна.



22064

ЭД МАТЕРИАЛЫН ХОХИРОЛТОЙ ОСОЛ



3238

ХҮН ГЭМТСЭН ОСОЛ

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, учирсан хохирол:

Монгол Улсын хэмжээнд 2019 онд цагдаагийн байгууллагад нийт 31524 гэмт хэрэг бүртгэгдсэний дотор Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1276 бүртгэгдэж нийт гэмт хэргийн 4%-ийг эзэлсэн нь өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахд хувийн жин 0,6% өсчээ. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 825 (84.8%) эрэгтэй жолооч, 148 (15,2%) эмэгтэй жолооч эзэлж байна. 18-34 насны залуу хүмүүс 67%-ийг эзэлж байна. Гэмт хэргийг ангилалаар авч үзвэл 1232 буюу 96,5% хөнгөн, 44 буюу 3,4% нь хүнд хэрэг бүртгэгдсэн байна.

Зам, тээврийн ослын улмаас амт насаа алдсан, гэмтсэн хүн, хохирсон хохирол:

Он	Зам, тээврийн осол		Гэмт хэргийн улмаас					
			Хэрэгт өртсөн		Амь насаа алдсан		Гэмтсэн	
	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд
2019	1276	595	1391	646	319	85	1072	561
Он	Зам, тээврийн осол		Зам, тээврийн ослын улмаас					
			Осолд өртсөн		Амь насаа алдсан		Гэмтсэн	
	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд
2019	25302	21874	4351	2836	561	131	3790	2705

2019 онд Монгол Улсын хэмжээнд 31524 гэмт хэргийн улмаас 934 хүн нас барсны 34.2 хувь нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ. Өнгөрсөн оны үзүүлэлтээс 0,4%-иар буурсан.

4351

ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДЭЭРЭЭ ХОХИРСОН НИЙТ ХҮН



3790

ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС ГЭМТСЭН ХҮН

561

ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС АМЬ НАСАА АЛДСАН ХҮН

Зам, тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний тоон үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад улсын хэмжээнд 0,2%, нийслэлийн хэмжээнд 6,4% буурч, орон нутагт 1,9%-ийн өсөлттэй байна.

Зам, тээврийн ослын шалтгаан:

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 25302 зам, тээврийн ослын 24741 буюу 97.8 хувь нь жолоочийн буруугаас, 530 буюу 2.1 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 31 буюу 0.2 хувь нь замын нөхцлөөс шалтгаалсан байна.

Бүртгэгдсэн зам, тээврийн ослын 97.8 хувь нь жолоочийн буруутай үйлдэл буюу хууль, дүрэм зөрчсөн, сахилга хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна.

Улсын хэмжээнд 2019 онд зам, тээврийн осол 14,5 хувиар буурчээ. Зам, тээврийн ослын шалтгаан, нөхцлийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан судалж үзэхэд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол 22,4%-иар, эргэх үйлдэл буруу хийсэн 11,9%, бүрэн бус тээврийн хэрэгслээс шалтгаалсан осол 4,8%-иар тус тус өсчээ.

Зам, тээврийн ослын төрөл:

Төрөл		Онхолдох	Тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх	Тээврийн хэрэгслээр явган хүн дайрсан	Тээврийн хэрэгслээр дугуйтай хүн дайрсан	Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөсөн	Зорчигч унагасан	Мал амьтан дайрсан	Бусад
Улсын хэмжээнд									
2019	тоо	1071	20764	1996	88	986	75	162	160
	эзлэх хувь	4,2	82,1	7,9	0,3	3,9	0,3	0,6	0,6
Нийслэлд									
2019	тоо	106	19188	1657	68	782	27	34	12
	эзлэх хувь	0,5	87,7	7,6	0,3	3,6	0,1	0,2	0,1

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам, тээврийн ослын 20764 буюу 82,1% нь мөргөлдөх, 1996 буюу 7,9% нь явган зорчигч мөргөх, 1071 буюу 4,2% нь онхолдох, 986 буюу 3,9% үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн/ 75 осол зорчигч унагах, 88 тохиолдолд унадаг дугуйтай хүн мөргөх, 162 осол мал, амьтан дайрах, 160 осол бусад хэлбэрийн төрөлд хамаарч байна. /Хүснэгт 9/

Зам, тээврийн осол гарсан улирал, цаг агаар:

Зам, тээврийн ослын 27,6% нь өвөл, 25,7% нь хавар, 21,4% нь зун, 25,3% нь намар бүртгэгджээ. Хүний амь нас хохирсон осол зун, намрын улиралд их бүртгэгдсэн байхад өвлийн улиралд хальтиргаа гулгаанаас хамааралтай гэмтэл бэртэл авах нь ихэссэн байна. Хүний амь нас хохирсон ослын 29,5% нь шөнө, 70,5% нь өдрийн цагт гарчээ.

Хүүхэд өртсөн зам, тээврийн осол:

Улсын хэмжээнд 2019 онд амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан 3238 бүртгэгдсэний 745 осолд хүүхэд өртөж хохирсон байна. Хүүхэд өртсөн ослын улмаас

819 хүүхэд амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ. Амт нас, эрүүл мэндээрээ хохирсон хүүхдийн 49 хүүхэд амь насаа алдаж, 770 хүүхэд эрүүл мэндээрээ хохирсоны 143 хүүхэд хүнд, хүндэвтэр гэмтэл авчээ. 2019 онд 0-6 насны 23 хүүхэд, 7-14 насны 24 хүүхэд, 15-с дээш насны 2 хүүхэд амь насаа алдсан ба 22 эмэгтэй, 27 эрэгтэй хүүхэд байжээ. Үүнээс замын хөдөлгөөнд явганаар оролцож байсан 23 хүүхэд, тээврийн хэрэгслээр зорчиж байсан 26 хүүхэд амь насаа алдсан байна.

819

ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДЭЭРЭЭ ХОХИРСОН НИЙТ ХҮҮХЭД



770

ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС
ГЭМТСЭН ХҮҮХЭД

49

ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС
АМЬ НАСАА АЛДСАН ХҮҮХЭД

Улсын хэмжээний 2019 онд зам, тээврийн осолд өртсөн, хохирсон хүүхдийн статистик мэдээллийг өнгөрсөн оныхтой харьцуулахад амь насаа алдсан хүүхэд 22,9%-иар өсч, гэмтсэн хүүхэд 23.3 хувиар буурчээ.

Зам, тээврийн осолд холбогдсон автомашин:

Судалгаанд хамрагдсан 21282 автомашины үйлдвэрлэгдсэн улс, орноор:

- Япон - 73,8%,
- Солонгос - 20,0%
- Хятад – 3,6%
- Герман – 1,0%
- Америк – 0,5%
- ОХУ – 0,3
- Бусад – 178 – 0,8%

Зам, тээврийн осолд холбогдсон автомашины марк, загвараар гаргасан бүртгэлд Toyota, Hundai, Nissan, Honda загварын автомашин дийлэнх хувийг эзэлж байгаа нь Монгол Улсад дээрх загварын автомашины хэрэглээ өндөр, тоо хэмжээ давамгайлж байгаатай холбон үзэж болно.

Жолоочийн тоон үзүүлэлт:

Монгол улсын жолоочийн бүртгэлийн санд 1265544 жолооч бүртгэлтэй, 2019 онд шинээр 63154 жолооч нэмэгджээ. 2010 онд 648825 жолоочтой байсан бол жолоочийн тоо 2019 оны байдлаар 95,1%-иар өссөн байна. Нийт жолоочийн 37,7% эмэгтэй, 62,2% эрэгтэй жолооч байна.

Сүүлийн 20 жилд Монгол улсын хэмжээнд 348147 зам, тээврийн осол, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 30132 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 7324 хүний амь нас хохирч, 24144 хүн гэмтжээ.

Дэлхийн дахинд зам, тээврийн ослын гэмтлийн улмаас 1,35 сая хүн амт насаа алдаж, нийгэм, эдийн засагт хохирол учруулсаар байна. Монгол Улсын 100000 хүнд ногдох зам, тээврийн ослын нас баралт 16,5 байнаа нь дэлхийн улс орнуудын дундаж үзүүлэлтээс 1,7 хүнээр бага үзүүлэлттэй байна.

8. ДҮГНЭЛТ

Зам, тээврийн салбар нь өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшилтай манай улсын эдийн засгийн чухал салбарын нэг юм. Монгол Улсад авто зам, автотээвэр, төмөр замын тээвэр, агаарын тээвэр болон усан замын тээвэр гэсэн үндсэн салбарууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсад 2019 онд бүх төрлийн тээврээр нийт 69 сая тн ачаа тээвэрлэсэн бөгөөд үүнээс автотээврээр 40,8 сая тн, төмөр замын тээврээр 28,1 сая тн, агаарын тээврээр 5,76 мянган тн ачаа тус тус тээвэрлэсэн байна. Ачаа тээвэрлэлт өмнөх онтой харьцуулахад 1,17 сая тн буюу 1,7%-иар өссөн ба үүнээс автотээвэр 2,8%-иар буурч, төмөр зам 9,2%, агаарын тээвэрлэлт 0,2% өссөн байна.

Давхардсан тоогоор 2019 онд 173 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 23,99 сая хүн зорчигч буюу 12,2%-иар буурсан байна. Үүнээс автотээврээр 168,44 сая хүн, төмөр замын тээврээр 2,95 сая хүн, агаарын тээврээр 1,62 сая хүн, усан замын тээврээр 30,9 мянган хүн зорчигч тус тус тээвэрлэсэн байна. Автотээврийн зорчигч тээвэрлэлт өмнөх оныхоос 12,7%-иар буурсан нь салбарын нийт зорчигч тээвэрлэлтийн үзүүлэлт буурахад ихээхэн нөлөөлж байна. Буурсан шалтгааныг авч үзвэл 2015 оноос нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээ цахим төлбөрийн системд шилжсэн бөгөөд 2017 оноос төлбөрийг зөвхөн картаар хийдэг болсноор зорчигчид картаа тэр бүр цэнэглүүлэхгүй, бэлэн мөнгөөр зорчиж байгаа болон бусад зөрчлийн улмаас бүртгэгдэхгүй байгаа зэрэг шалтгаан нь салбарын нийт зорчигч тээвэрлэлт буурахад нөлөөлсөн гэж үзэж байна. Энэхүү зөрчлийг бууруулах, илрүүлсэн зөрчил бүрд холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байгаа юм.

Салбарын хэмжээнд 2019 онд нийт 2 их наяд төгрөгийн орлого бүрдүүлснээс автотээврийн салбар 796,06 тэрбум төгрөг, төмөр замын салбар 708,62 тэрбум төгрөг, агаарын тээврийн салбар 498,2 тэрбум төгрөг, усан замын тээвэр 0,4 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Монгол Улсад чанартай, хүртээмжтэй авто замын сүлжээг бий болгохоор сүүлийн жилүүдэд гадаадын зээл, тусламж, улсын төсөв, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд эрчимтэй явуулснаар улсын хэмжээнд авто замын сүлжээний нийт урт 2019 оны байдлаар 111,9 мянган км байна. Үүнээс 14 918,7 км нь улсын чанартай, 96 125,3 км нь орон нутгийн чанартай авто замд хамаарч байна. Улсын чанартай авто замын 7 469 км нь хатуу хучилттай, 6 314,1 км нь ердийн хөрсөн, 923,56 хайрган хучилттай, 211,9 км нь сайжруулсан хөрсөн авто зам байна.

Уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан экспортын бүтээгдэхүүн жил бүр нэмэгдэж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой байна. Энэ нь тээврийн салбарын Улсын эдийн засагт оруулах хувь нэмрийг өсгөж байгаа билээ.

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар нийт 1 049 474 тээврийн хэрэгсэл, 940 221 автомашин бүртгэлтэй байна. Үүнээс нийт автомашины 533 613 буюу 56,8%, тээврийн хэрэгслийн 572 926 буюу 54,7% нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Монгол Улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслээс 664 573 буюу 63,7% нь, нийт автомашины 619 098 буюу 66,3%, нийт суудлын автомашины 453 927 буюу 68% нь техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байна. Импортоор 2019 оны

байдлаар нийт 158 224 тээврийн хэрэгсэл орж ирснээс 69 472 буюу 43,9% нь суудлын автомашин, 54 632 буюу 32,6%-ийг мотоцикл болон дугуй, 37 191 буюу 23,5%-ийг ачааны, тусгай зориулалтын болон бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна. 2019 онд импортоор 69 472 суудлын автомашин орж ирсэн нь өмнөх оноос 5433 буюу 8,5%-иар өссөн байна. Монгол улсад тээврийн хэрэгслийн эрэлт хэрэгцээ жил бүр нэмэгдсэн үзүүлэлттэй байгааг статистик мэдээллээс харж байна.

2019 онд зам, тээврийн ослын шинжтэй 77444 дуудлага хүлээн авч, 25302 зам, тээврийн осол бүртгэн шалгасан байна. Өмнөх оныхтой харьцуулахад дуудлага 3767 буюу 4,6%-иар, бүртгэгдсэн осол 4172 буюу 14,2%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд хүлээн авсан дуудлагын 96%, бүртгэгдсэн ослын 86,5%-ийг НИЙСЛЭЛ эзэлж байна. Зам, тээврийн ослын улмаас 2019 онд 4351 хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирсон нь өмнөх оноос 18,3% буурсан боловч амь насаа алдсан хүний тоо 11,3%-иар болж өссөн байна. Амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүний 819 буюу 18,8% нь хүүхэд байгаа бөгөөд үүнээс 49 хүүхэд нас барсан байна. Нийт ослын 97,8%-ийг жолоочийн буруутай үйлдэл, 2,1%-ийг явган зорчигчийн буруутай үйлдэл, 0,2%-ийг замын нөхцлөөс шалтгаалсан гэж бүртгэжээ.

Зам, тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, осол гэмтэл түүний үр дагаврыг бууруулах тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж үр нөлөөг тооцох нь чухал байдаг. Энэ үйл ажиллагаанд хурд хэтрүүлэх болон согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохыг бууруулах, мотоциклын хамгаалалтын малгай, суудлын даруулга, хүүхдийн хамгаалах хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна.

ХАВСРАЛТ*

Хүснэгт 10.

Сайжруулсан авто замын урт, км

Он	Хатуу хучилттай	Хайрган хучилттай	Сайжруулсан хөрсөн зам	Нийт сайжруулсан авто зам
1950	182,0			1 029,0
1960	253,6			1 901,1
1970	387,0			2 826,5
1980	712,2			3 341,4
1985	920,6			3 613,4
1986	966,0			3 680,0
1987	1 006,7			3 729,6
1988	1 093,5			3 949,5
1989	1 184,6			4 249,7
1990	1 243,0			4 316,7
1991	1 294,0			4367,9
1992	1 303,0			3 076,0
1993	1 308,3			3 100,7
1994	1 359,3			3 162,7
1995	1 413,4			3 222,7
1996	1 471,4			3 325,1
1997	1 519,3			3 350,1
1998	1 531,7			3 351,3
1999	1 563,3			3 387,6
2000	1 567,4	938,43	947,67	3 453,5
2001	1 572,7	1 943,3	1 923,6	3 522,7
2002	1 801,9	1 871,3	1 873,6	3 673,2
2003	1 900,7	1 892,57	1 873,6	5 666,9
2004	1 900,7	1 937,8	1 844,8	5 683,3
2005	2 278,6	1 980,3	1 867,8	6 126,7
2006	2 392,8	1 980,27	1 907,8	6 280,8
2007	2 597,2	1 961,96	1 902	6 461,2
2008	2 671,2	1 999,81	1 874	6 545,0
2009	2 824,0	1 994,3	1 874	6 692,3
2010	3 015,6	2 071,58	1 647,2	6 734,4
2011	4 063,4	1 959,23	1 610,75	7 633,4
2012	4 082,9	1 959,23	1 610,75	7 652,9
2013	5 838,2	1 864,81	1 172,6	8 875,6
2014	5 838,2	1 782,5	1 184,7	8 875,6
2015	7 125,3	1 715,62	971,2	9 812,1
2016	7 456,61	1 696,82	972,6	10 126,0
2017	8 431,4	1308,9	614,9	10 355,2
2018**	9 022,7	1207,9	604,9	10 835,8
2019	9781	1207,9	604,9	11 593,8

* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

Зорчигч тээвэрлэлт, сая хүн*

Он	Нийт	Тээврийн төрөл			
		Төмөр замын тээвэр	Авто тээвэр	Агаарын тээвэр	Усан зам
1940	0,9	-	0,9	-	-
1950	0,9	-	0,9	-	-
1960	18,1	0,4	17,6	0,1	-
1970	53,4	0,7	52,4	0,2	-
1980	122,1	1,4	120,2	0,5	-
1986	183,9	2,4	180,9	0,6	-
1987	197,3	2,5	194,1	0,7	-
1988	234,5	2,6	231,1	0,8	-
1989	242,2	2,7	238,7	0,8	-
1990	232,2	2,6	228,8	0,8	-
1991	234,4	2,5	231,3	0,6	-
1992	252,2	2,6	249,3	0,3	-
1993	191,8	2,3	189,3	0,2	-
1994	146,8	2,9	143,7	0,2	-
1995	110,3	2,9	107,2	0,2	-
1996	109,1	3,0	105,9	0,2	-
1997	80,8	3,7	76,8	0,3	-
1998	81,5	3,9	77,3	0,3	-
1999	87,6	4,1	83,3	0,2	-
2000	93,0	4,3	88,4	0,3	-
2001	98,5	4,1	94,1	0,3	-
2002	105,7	4,0	101,4	0,3	-
2003	167,9	3,9	163,7	0,3	-
2004	194,2	4,3	189,6	0,3	-
2005	192,8	4,2	188,2	0,3	-
2006	195,4	4,3	190,7	0,555**	-
2007	209,9	4,5	205,0	0,608**	-
2008	231,6	4,3	226,9	0,606**	-
2009	232,5	3,1	229,0	0,538**	0
2010	250,7	3,5	246,7	0,67**	0,01
2011	296,2	3,8	291,8	0,892**	0,01
2012	317,97	4,0	313,16	1,098**	0,04
2013	307,94	3,8	303,38	1,106**	0,03
2014	344,18	3,31	340,15	1,019**	0,04
2015	260,0	2,8	256,5	0,955**	0,05
2016	264,0	2,6	260,7	1,023**	0,03
2017	215,7	2,6	212,2	1,251**	0,02
2018	200,42	2,57	196,9	1,422**	0,01
2019	173	2,95	168,44	1,62	0,03

* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

** ИНЕГ-ын мэдээлэл

Ачаа тээвэрлэлт, мян.тн*

Он	Нийт	Тээврийн төрөл			
		Төмөр замын тээвэр	Авто тээвэр	Агаарын тээвэр	Усан замын тээвэр
1925	0,4	0,0	0,4	0,0	0,0
1930	4,9	0,0	4,9	0,0	0,0
1935	69,8	0,0	69,8	0,0	0,0
1940	38,0	0,0	38,0	0,0	0,0
1942	165,4	148,8	16,6	0,0	0,0
1945	216,1	191,0	25,1	0,0	0,0
1950	323,1	270,0	53,1	0,0	0,0
1953	765,6	678,0	73,8	0,0	13,8
1955	1 282,2	1 119,9	146,1	0,0	16,2
1960	8 037,5	3 913,2	4 102,9	0,7	20,7
1965	11 294,9	2 375,0	8 894,7	1,8	23,4
1970	14 465,5	4 724,6	9 710,7	2,8	27,4
1975	20 911,0	6 861,7	13 995,7	5,1	48,5
1980	33 149,0	9 800,0	23 300,0	9,0	40,0
1985	50 950,0	15 000,0	35 900,0	10,0	40,0
1988	63 658,0	17 800,0	45 800,0	14,0	44,0
1990	54 038,5	14 517,1	39 438,9	10,9	71,6
1995	8 950,8	7 298,0	1 648,5	2,7	1,6
1996	9 451,8	7 466,0	1 982,0	2,7	1,1
1998	8 867,3	7 615,1	1 247,4	3,5	1,3
1999	9 534,0	8 199,3	1 330,4	2,8	1,5
2000	10 643,4	9 158,5	1 480,4	2,9	1,6
2001	11 810,5	10 147,7	1 658,2	2,9	1,7
2002	13 529,9	11 637,0	1 888,7	2,4	1,8
2003	17 622,8	12 284,7	5 335,9	2,2	0,0
2004	21 596,0	14 031,8	7 561,9	2,3	0,0
2005	23 670,5	15 586,3	8 081,7	2,0	0,5
2006	23 971,38	14 779,8	9 189,4	3,3**	-
2007	23 281,62	14 072,6	9 207,1	3,6**	-
2008	23 904,43	14 646,9	9 255,7	4,1**	-
2009	24 736,7	14 164,5	10 563,8	3,5**	-
2010	29 415,91	16 804,0	12 610,2	4,5**	-
2011	44 085,95	18 447,74	25 635,28	6,2**	-
2012	50 644,29	20 445,19	30 195,09	6,6**	-
2013	42 361,41	21 035,5	21 321,86	6,5**	-
2014	44 636,18	21 118,59	23 514,15	5,5**	-
2015	32 197,3	19 150,8	13 043,7	4,7**	-
2016	40 398,4	19 989,14	20 406,17	4,85**	-
2017	53 981,08	22 765,1	31 212,9	5,37**	-
2018	67 802,88	25 763,3	42 033,78	5,75**	-
2019	68 975,68	28 121,2	40 848,75	5,76	-

* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

** ИНЕГ-ын мэдээлэл

Хүснэгт 13.

Тээврийн нийт орлого, тэрбум төгрөг*

Он	Нийт	Тээврийн төрөл			
		Төмөр замын тээвэр	Авто тээвэр	Агаарын тээвэр	Усан замын тээвэр
1993	19,97	9,68	5,72	4,57	-
1994	27,03	13,5	6,18	7,35	-
1995	36,04	16,05	8,52	11,45	0,01
1996	44,07	20,73	10,23	13,1	0,01
1997	64,98	27,33	12,95	24,68	0,01
1999	79,5	35,79	13,16	30,53	0,01
2000	102	47,8	14,5	39,7	0,02
2001	120,8	63,21	15,97	41,64	0,02
2002	152,8	86,64	17,8	48,38	0,02
2003	193,7	109,9	32,7	51,09	0,02
2004	242,6	135	44,12	63,5	0,02
2005	309,5	193,6	44,25	71,63	0,02
2006	311,8	182,61	46,13	83,09	0,02
2007	342,3	173,33	76,1	92,82	0,02
2008	419,2	204,89	100,1	114,14	0,07
2009	465,6	226,42	128,46	110,7	0,03
2010	593,6	306,92	172,19	144,48	0,01
2011	854,8	390,89	299,31	164,46	0,13
2012	1 041,2	416,52	417,55	206,91	0,16
2013	1 045	421,42	376,15	247,29	0,15
2014	1 038,3	427,86	363,75	246,2	0,53
2015	987,9	387,94	345,05	254,34	0,58
2016	1 191,5	441,8	467,17	287,28	0,23
2017	1 422,3	530,02	506,43	385,53	0,3
2018	1 687	616,48	627,8	442,2	0,5
2019	2 003,05	708,62	796,06	498,2	0,4

Хүснэгт 14.

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо**

Он	Нийт тээврийн хэрэгсэлийн тоо	Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэл	
		Тоо	Хувь
2012	608 255	386 369	63,5%
2013	673 106	427 711	63,5%
2014	739 589	477 199	64,5%
2015	789 720	476 047	60,2%
2016	841 552	511 911	60,8%
2017	900 125	551 537	61,2%
2018	970 815	634 669	65,3%
2019	1 049 474	664 573	63,3%

* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

** "АТҮТ" ТӨҮГ-ын VRS автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн мэдээлэл

